

Гар утасны цэнэг дуусчихаад цэнэглэгч, залгуур хайн сандардаг цаг тvvх болон vлдэх нь. Сеулийн эрдэмтдийн бvтээсэн тvvхэн дэх хамгийн сонирхолтой нээлт хэмээн онцолж буй тохооромж хэрэглэгчдэд гар утасны шинэ эринийг авчирч байна. Тус хотын Сункюнкваны их сургуулийн эрдэмтдийн баг дуу

авиаг цахилгааны энерги болгодог тохооромж бvтээснээ онгорогч долоо хоногт нийтэд танилцуулжээ.

Уг тохооромжийн тусламжтайгаар гар утас хэрэглэгчид утастайгаа ярих тодийд л цэнэглэх богоод хэдий чанга ярих тусам цэнэглэх хvчдэл нэмэгдэх гэнэ. Шинжээчдийн таамаглаж буйгаар уг тохооромжийг хэрэглээнд нэвтрvvлэх нь олон нийтийн газар чанга чанга хашгичин утсаар ярих хvмvvсийн тоо нэмэгдэх сорог талтай хэмээн vзэж буй юм. Хэрэв та ярихаас тvвэгшээж байгаа бол утсандаа хогжим “сонсгож” ч болох гэнэ.

Энэ тухай судалгааны багийн ахлагч Санву Ким “Хvн торолхтний сэтгэлийг тvгшээж буй сэргээгдэхгvй эрчим хvчний асуудлыг шийдэхэд бидний нээлт багагvй тус болно. Учир нь дуу чимээ гэдэг хvний одор тутмын амьдралд байнга бий болдог хvчин зvйл. Үvнийг эрчим хvчний эх vvсвэр болгоно гэдэг чухал ач холбогдолтой” гэжээ.

**У.ТЭНҮҮН**